



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/59

Рашаант сум

Худалдаа үйлчилгээ эрхлэгч
иргэн аж ахуйн нэгжүүдэд
хяналт тавих тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 16.4.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад ДЭМБ-ын хийсэн судалгаагаар өсвөр насны хүүхдийн тархины хөгжилд электрон тамхи /vape/ буюу электрон никотин дамжуулах системийн хэрэглээ нь урт хугацаанд сөргөөр нөлөөлж, сэтгэл түгших эмгэг, оюуны хомсдол, никотины донтолт, уушги цоорох эмгэг зэргийн үүсгэж эрүүл мэнд, амь насанд сөрөг нөлөө үзүүлж байгааг тогтоосонтой холбоотойгоор сумын өсвөр насны хүүхдийн электрон тамхины хэрэглээг бууруулах, эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс насанд хүрээгүй хүүхдэд электрон тамхи, утаат тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосугай.

2. Өсвөр насны хүүхдийн электрон тамхи болон утаат тамхины хэрэглээг багасгах, эрүүл мэндэд сөрөг нөлөөний талаар олон талт арга хэмжээ авч ажиллахыг Сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн (А.Лхагвасүрэн), Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан (Б.Урангоо), Сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Саруул) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тамхи худалдан борлуулдаг аж ахуйн нэгжүүдэд иргэдийн санал гомдлыг үндэслэн шалгалт хийж зөрчил илэрсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Сумын хэсгийн төлөөлөгч (Б.Ренчиндорж), Хэсгийн цагдаа (Н. Наранбаатар), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Г.Амаржаргал) нарт тус тус даалгасугай.

6706011097

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Т. Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Б.АЛТАНГЭРЭЛ